



# “ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 02 сарын 02 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,  
Төмөрчний гудамж - 8, 405 тоот  
Утас: +976 7711-4519, 88472789, 88112654  
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### ИНВЕСКОР АКТИВ ТЗК ХХК-ИЙН УДИРДЛАГАД

#### Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бусад хураангуйг багтаасан санхүүгийн тэмдэглэлээс бүрдсэн “Инвескор актив ТЗК” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Инвескор актив ТЗК” ХХК-ийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

#### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### *Санхүүгийн тайлангийн талаар Удирдлагын хүлээх Үүрэг, Хариуцлага*

Удирдлага нь СТОУС-уудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан, эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь Байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.


#### *Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. Санхүүгийн тайлангийн аудитад хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын талаарх тус компанийн тодорхойлолт нь манай аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

### ***Тайлангийн хэрэглээ***

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох “Инвескор актив ТЗК” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



---

Лидер экаунт аудит ХХК  
Захирал П.Шаравхорол  
2023 оны 02 сарын 02